



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/01

Хараат

2023 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, Батлан хамгаалах сайдын 2017 оны А/322 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам”, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/552 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны цэргийн бүртгэл явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: -Ш.Мөнх-Оргил (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: -Г.Жаргалмаа (1 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд: -Б.Азжаргал (Хэсгийн төлөөлөгч)

-Э.Баярмаа (2 дугаар багийн Засаг дарга)

-Ц.Ундрахбаяр (3 дугаар багийн Засаг дарга)

-Б.Балжинням (4 дүгээр багийн Засаг дарга)

-Г.Эрдэнэтуяа- (Бичиг хэргийн ажилтан)

2. Хугацаат цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл үүрэгтэй иргэдийн цэргийн бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 20-ны дотор зохион байгуулж явуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Мөнх-Оргил), ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Багийн Засаг дарга нарт даалгах нь:

3.1 Дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад заагдсан “Улсын дайчилгааны төлөвлөгөө”, “Зэвсэгт хүчний анги байгууллагыг хүн хүч, техникээр хангах төлөвлөгөө”, “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний дагуу цэргийн дайчилгааны даалгавар, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн оногдуулан данслагдсан

4823000010

бэлтгэл үүрэгтэй иргэд, авто техник, өөрөө явагч хэрэгсэл, ангийн буу зэргийг нэгбүрчлэн бүртгэн тоолж даалгаваржуулах

3.2 Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэн батлагдсан “Батлан хамгаалах”-ын багц хууль, 2018 онд батлагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”, ЗГ-ын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр хаах журам”, 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн гэрээт алба хаах журам” зэрэг хууль эрх зүйн мэдээлэл, цэргийн жинхэнэ алба хаах тухай цахим хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулж тайланг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны дотор Тамгын газарт ирүүлэх

3.3 Цэргийн бүртгэлийн зөрчилтэй, завсардагчид болон цэрэг татлагаас зайлсхийсэн, хамрагдаагүй цэргийн үүрэгтнүүдийг бүртгэлд хамруулах ажилд хэсгийн төлөөлөгч, улсын бүртгэгч, холбогдох албан тушаалтнуудыг татан оролцуулах, тоо бүртгэлийн журам зөрчигчдийн нэрсийн жагсаалтыг гарган ямар арга хэмжээ авсан тухай мэдээг заасан хугацаанд Цэргийн штабт хүргүүлэх.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН

